



ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 1791

Чингис хот

Мал амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 Эрүүл ахуйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дүгээр Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/181 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Мал, амьтны сэг зэмээс хүн малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг Мал эмнэлгийн байгууллагын заавар зөвлөмжийн хүрээнд Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, Байгаль орчны алба, Багийн Засаг дарга нар Өндөрхаан тохижилтын ОНӨААҮТ газартай хамтран орон нутгийн малчид, мал бүхий иргэдийн оролцоотойгоор 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 25-ныг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал, амьтны сэг зэм устгалын ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, ажлын гүйцэтгэлийг заасан хугацаанд сумын ЗДТГ-ын даргын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Г.Лхагвабаатар/-т тайлагнахыг Багийн засаг дарга, Тосгоны захирагч нарт үүрэг болгосугай.

3. Мал амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга /Д.Сандагдорж/-д, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллах Байгаль орчны улсын байцаагч /Д.Буянбат/-д даалгасугай.

4. Сэг зэм устгал орчны халдваргүйтгэлд шаардагдах зардлыг гамшгийн эрсдэлийн сангаас Нягтлан бодогч /Д.Баярцэцэг/-д зөвшөөрсүгэй.

5. Сэг зэм устгал орчны халдваргүйтгэлд шаардлагатай автомашин, техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг Өндөрхаан тохижилтын газрын дарга /Э.Мөнхбат/-д, шаардлагатай бараа материалаар хангаж ажиллахыг Зохион байгуулалт, үйлчилгээ, асуудал хариуцсан ажилтан /Л.Ганбаатар/-д даалгасугай.

6. Сэг зэм устгал орчны халдваргүйтгэлийн явцын мэдээ, мэдээ тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга /Д.Сандагдорж/-д даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /А.Борбил/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР